



# АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА

МОНГОЛ УЛСАД ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ



Sant-Maral Foundation



Энэхүү судалгааг Австралийн Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яамны өгөөмөр дэмжлэгтэйгээр хийсэн болно. Судалгааг Азийн сан, Сант Марал сантай хамтран явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Австралийн Засгийн газар болон Австралийн Гадаад хэрэг, худалдааны яамны үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

Хавтасны зургийг:

С.Мандахжаргалбаатар

Э.Энхтулга

---

# АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА

---

Монгол Улсад ил тод байдлыг бэхжүүлэх нь төсөл

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

2015 он

## АГУУЛГА

I.	Оршил .....	7
II.	Судалгааны гол үр дүн .....	8
III.	Судалгааны арга зүй .....	9
	1. Үндсэн асуудлууд .....	11
	2. Сонгуулийн үр дүнгийн ил тод, шударга байдлын хүлээлт .....	13
	3. Авлигын түвшин .....	16
	4. Авлигын чиг хандлагын үнэлгээ .....	19
	5. Авлигатай тэмцэх .....	21
	6. Авлигын эсрэг санаачлага .....	27
	7. Шударга хандлага .....	29
	8. Дээд түвшний авлигын тухай ойлголт .....	30
	9. Өрхийн түвшний авлига .....	35
	10. Олон нийтийн хандлагыг тодорхойлж буй хүчин зүйлс .....	39
	11. Хүн ам зүйн мэдээлэл .....	40
IV.	Судалгаанд ашигласан асуулга .....	43

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ:

Зураг 1.1:	Үндсэн асуудлууд (1 сонголт хийнэ) .....	11
Зураг 1.2:	Ажилгүйдэл .....	12
Зураг 1.3:	Авлига .....	12
Зураг 1.4:	Авлига манай улсад тогтсон заншил болсон .....	12
Зураг 2.1:	Ер нь сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэжта бодожбайна вэ? (Бодит %)	13
Зураг 2.2:	Ер нь сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэжта бодожбайна вэ? .....	15
Зураг 2.3:	Сонгуулийн үе шат тус бүрийн хариултын дундаж утга (1-ээс = “Огт үгүй” 4 = “Их хэмжээгээр” хүртэл) .....	16
Зураг 3.1:	Авлигын нөлөө .....	16
Зураг 3.2:	Авлигын цар хүрээ (1-ээс = “огт үгүй” 5= “маш ихээр” хүртэл) .....	18
Зураг 3.3:	Авлигын цар хүрээ .....	18
Зураг 3.4:	Улаанбаатар/Орон нутаг гэсэн үнэлгээ .....	19
Зураг 4.1:	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? .....	20
Зураг 4.2:	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? .....	20
Зураг 5.1:	Авлигатай тэмцэхэд саад болдог хүчин зүйлс (1-ээс = “огт үгүй” 4= “ихээр” хүртэл) .....	21
Зураг 5.2:	Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам .....	22
Зураг 5.3:	Авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (1 сонголт хийнэ) .....	23
Зураг 5.4:	Таны бодлоор одоогийн Засгийн газар өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ? .....	23
Зураг 5.5:	Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг Та хэрхэн үнэлж байна вэ? .....	24
Зураг 5.6:	Авлигатай тэмцэх газарт Та хэр зэрэг итгэдэг вэ? .....	24
Зураг 5.7:	Та Авлигатай тэмцэх газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддагт итгэдэг үү? .....	25
Зураг 5.8:	Авлигын эсрэг хууль батлагдсанаас хойш хуулийн хүрээнд аль нэг албан тушаалтан шийтгүүлсэн тухай Та сонссон уу? .....	25
Зураг 5.9:	Та авлигын талаар мэдээлэл авах утас ажиллаж байгааг мэдэх үү? .....	26
Зураг 5.10:	Хэрвээ Авлигатай Тэмцэх газар нэр хаяггүй мэдээлэл хүлээж авна гэвэл Та авлигын талаар мэдээлэл өгөх үү? .....	26
Зураг 6.1:	Дараах арга хэмжээнүүд хэр ЧУХАЛ гэж та бодож байна вэ? .....	28

Зураг 6.2:	Дараах арга хэмжээнүүдийг хэр зэрэг ҮР ДҮНТЭЙ байна гэж та бодож байна вэ? .....	28
Зураг 7.1:	Боловсрол болон эрүүл мэндийн салбарын шударга харилцаа .....	29
Зураг 7.2:	Шүүхийн тогтолцоо болон хууль сахиулах байгууллагын шударга харилцаа .....	29
Зураг 7.3:	Орон нутгийн болон төрийн захиргааны шударга харилцаат .....	30
Зураг 8.1:	Дээд түвшний авлигын тодорхойлолт .....	31
Зураг 8.2:	Дээд түвшний авлига Монголд яагаад оршиж байна вэ? .....	31
Зураг 8.3:	Монгол дахь дээд түвшний авлигын түвшин .....	32
Зураг 8.4:	Та дээд түвшний авлигын талаар хэр их олж сонсдог вэ? .....	32
Зураг 8.5:	Хэрэв сонссон бол ямар хэлбэрийн авлига байсан бэ? .....	33
Зураг 8.6:	Дээд түвшний авлига Та болон таны гэр бүлийн амьдралд хэр нөлөөлдөг вэ? .....	33
Зураг 8.7:	Дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (1 сонголт хийнэ) .....	34
Зураг 8.8:	Дээд түвшний авлигатай тэмцэхэд хамгийн их үр дүнтэй арга аль нь гэж та бодож байна вэ? .....	35
Зураг 9.1:	Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? .....	35
Зураг 9.2:	Хэрвээ авлигын тухай мэдэгдэх болвол хаана? .....	36
Зураг 9.3:	Өнгөрсөн 3 сарын хугацаанд Та эсвэл танай өрхийн гишүүн хахууль өгсөн үү? .....	37
Зураг 9.4:	Таны хахууль өгөх болсон гол шалтгаан юу байсан бэ? .....	37
Зураг 9.5:	Өрхийн төсөв нь “ноцтой хохирсон” өрхүүдийн хувь хэмжээ .....	38
Зураг 10.1:	Хандлагыг тодорхойлох гол хувьсагчууд .....	40
Зураг 11.1:	Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (Газар зүйн байршлаар) .....	41
Зураг 11.2:	Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (Хүйсээр) .....	41
Зураг 11.3:	Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (Орлогоор) .....	42
Зураг 11.4:	Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (Насаар) .....	42

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ:

Хүснэгт 1:	Түүврийн тархалт .....	10
Хүснэгт 3.1:	Авлигад их автсан байгууллага .....	17
Хүснэгт 10.1	Олон нийтийн хандлагыг тодорхойлж буй хүчин зүйлс .....	39

## I. ОРШИЛ

Азийн сан, Сант Марал сантай хамтран Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох 16 дахь удаагийн судалгаагаа Австралийн Гадаад хэрэг, худалдааны яамны дэмжлэгтэйгээр нийслэл Улаанбаатар хот болон аймаг, сумдыг хамруулан үндэсний хэмжээнд 2015 оны 4 сард явууллаа. Тус судалгааг 2006-2011 онуудад “Авлигын түвшин тогтоох” судалгаа нэрээр, 2012 оноос эхлэн “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох” судалгаа нэрээр явуулж байна.

“Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох” судалгаа нь тогтмол хугацаанд явагддаг үндэсний хэмжээний цөөн судалгааны нэг бөгөөд үр дүнг нь иргэний нийгмийн болон төрийн байгууллагууд өргөнөөр ашигладаг юм. Судалгаа нь төр засгийн бодлого тодорхойлогчид, иргэний нийгмийн байгууллагуудын хувьд олон нийтийг соён гэгээрүүлэх, тэдэнд ойлголт мэдлэг түгээх нэг чухал арга хэрэгсэл нь болдог. Судалгаа авлига, өндөр түвшний авлига, төрийн байгууллагууд дахь авлигын талаархи төсөөлөл болон өрхийн түвшин дэх авлигын тохиолдлыг судалдаг бөгөөд тогтмол хугацаанд давтан явуулах нь олон нийтийн ойлголт, хандлагад гарч буй өөрчлөлтийг тодорхойлох ач холбогдолтой юм.

2012 онд Азийн сан АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн Монгол Улсад Засаглал, ил тод байдлыг дэмжих нь төслийн хүрээнд авлигын талаарх бизнес эрхлэгчдийн ойлголт, төсөөллийг тодорхойлох зорилгоор Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааг эхлүүлсэн. Түүнчлэн эрүүл мэндийн салбарт судалгаа явуулснаас гадна 2015 оны намар үр дүн нь гарах салбарын нарийвчилсан судалгааг уул уурхай, барилга, худалдаа зэрэг салбаруудад явуулаад байна.

## II. СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

- Авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх хандлага 2013 оны хоёрдугаар хагасаас эхлэн өөрчлөгдөв.
  - 2013 оны 3-р сард Н.Алтанхуяг ерөнхий сайдын засгийн газар өмнөх засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 3-ны нэг буюу 35.1 хувь нь “Авлигын асуудлыг илүү сайн шийдвэрлэж байна” гэж хариулж байсан болон энэ судалгааны дүнгээр “Таны бодлоор одоогийн засгийн газар (Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн тэргүүлж буй) өмнөх засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ” гэсэн асуултанд 7.2 хувь нь “Авлигын асуудлыг илүү сайн шийдвэрлэж байна” гэж хариулжээ.
  - 2013 оны 9-р сард оролцогчдын гуравны нэгээс илүү буюу 41 хувь нь өнгөрсөн гурван жилд авлига нэмэгдсэн гэж үзэж байсан бол 2015 оны 4-р сард талаас илүү буюу 59 хувь нь авлига нэмэгдсэн гэж үзжээ.
  - 2013 оны 9-р сард оролцогчдын талаас дээш хувь нь буюу 52.5 хувь нь ирэх гурван жилд авлига буурна гэсэн итгэлтэй байсан бол энэ удаагийн судалгааны үр дүнгээр энэ тоо 27.4 болж буурчээ.
  - Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд өгөх үнэлгээ 2013 оны 9-р сараас 2014 оны 3 сар хүртэлх хугацаанд 29.4 хувиас 22.6 хувь болж өөрчлөгдсөн бол 2015 оны 4 сарын байдлаар 16.6 хувь болж буурсан. Мөн тус байгууллагад үзүүлэх иргэдийн итгэл 2013 онд 46.5 хувиас 2014 онд 45.7 хувь, 2015 онд 39.2 хувь болж буурчээ.
- 2006 оноос хойш оролцогчдын 80 гаруй хувь нь авлига нийгмийн үзэгдэл болсон гэдэгтэй их бага хэмжээгээр санал нийлдэг байсан бол 2015 оны 4-р сарын дүнгээр энэ тоо 85.3 болж өсчээ.
- Ирэх жилүүдэд болох сонгуулиудтай холбоотойгоор сонгуулийн сурталчилгааны санхүүжилттэй холбоотой авлигын асуудал гарна гэж оролцогчид хариулсан бөгөөд 53 хувь нь сонгуулийн сурталчилгааны санхүүжилт огтхон ч шударга, ил тод байхгүй гэж үзжээ.
- Энэ удаагийн судалгааны үр дүнгээр улс төрийн авлигын асуудал хурцаар гарч иржээ. Судалгаанд анх удаагаа авлигад хамгийн ихээр өртсөн газрын жагсаалтын эхний тавд улс төрийн намууд, Засгийн газар, УИХ гурав гурвуулаа оржээ.
- Авлигатай тэмцэхэд саад болж буй хүчин зүйлсийн нэг болох асуудлыг авлигаар шийдэх зуршил үнэлгээний хувьд 2012 оны 11 сард дундаж нь 3.45-аас 2015 оны 4 сард 3.12 болж хойшилсон. Харин авлигатай тэмцэх хууль тогтоомж, хүлээлгэх хариуцлагын асуудал боловсронгуй биш гэсэн хариулт эхний байр эзэлсэн.
- 2012 оноос хойш авлигатай тэмцэх үр дүнтэй арга замаар шийдмэг арга хэмжээ авах, хуулийг хэрэгжүүлэх гэдгийг нэрлэсээр байгаа билээ.



- Төрийн байгууллагаас авлигыг бууруулах, авлигатай тэмцэхэд технологийн дэвшлийг ашиглахыг үр дүн, ач холбогдлын хувьд хамгийн чухалд тооцжээ. Орлогчдын бараг гуравны хоёр буюу 71.6 хувь нь үүнийг маш их болон нэлээд чухал, 62.2 хувь нь маш их болон нэлээн үр дүнтэй гэж үзжээ.
- Төрийн дээд түвшинд ил тод байдал хангалтгүй байгаа нь 19.5 хувиар, мөн улс төр, бизнесийн ашиг сонирхол хутгалдсан байдал 19.1 хувиар Монгол Улсад их авлига байгаагийн хамгийн гол шалтгаан болж байна.

### III. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааг бүтэцчилэгдсэн болон ганцаарчилсан ярилцлага авах хэлбэрээр 18-с дээш насны буюу насанд хүрэгчидтэй хийсэн. Судалгаа нь санамсаргүй түүвэр болон магадлалын тархалтын аргачлалаар газар нутгийн бүлэглэлийн олон түвшнийг хамарсан.

Эхний шатанд Улаанбаатар хот болон Монгол Улсын дөрвөн бүс нутаг бүрээс нэгээс хоёр аймаг түүврийн аргаар сонгож авсан. Эдгээр аймгуудаас сумдуудыг, Улаанбаатар хотоос хороодыг санамсаргүйгээр сонгосон. Аймгийн төв болон сумын төвүүдийг (засаг захиргааны төвүүд) түүвэрт зайлшгүй хамруулсан.

Хоёрдугаар шатанд Түүврийн Анхан Шатны Нэгж болох Улаанбаатар хотын хороод, аймгийн төвүүдэд засаг захиргааны хамгийн бага нэгж болох багууд, харин сумын төвүүдэд судалгааны багийн ахлагч найман өрхөөс тогтсон бүлгийг анхан шатны судалгааны нэгж болгон сонгосон.

Гуравдугаар шатанд эхлэх цэг болон өрхүүдийг тодорхойлсон. Улаанбаатар хотын орон сууцны хорооллуудын байшин болон хаалганы дугаар бүхий хаягийг судлаачдад өгсөн. Ажлын ахлагч гэр хорооллын зөвхөн гудамжны дугаар болон эхлэх цэгүүдийг хуваарилсан. Гэр хороололд судлаачид эхлэх цэгээс эхний өрхийг алхсаад хоёр дахь өрхөөс эхлэн ярилцлага авч, дараа нь баруун гарын дүрмийг баримтлан гурав дахь өрх бүрийг сонгон ярилцлага хийсэн. Аймгийн төв болон сумын төвүүдэд ахлагч эхлэх цэгийг тодорхойлж судлаач баруун гарын дүрмээр гурав дахь өрх бүрийг сонгосон. Ярилцлагыг өрхийн тэргүүн эсвэл өрх гэрийн асуудлаар хамгийн их мэдлэгтэй хүнийг сонгож хийсэн.

Энэхүү тайланд 2015 оны 3-р сарын 30-ны өдрөөс 2015 оны 4-р сарын 16-ны хооронд хийгдсэн Авлигын Талаарх Олон Нийтийн Ойлголт Мэдлэг Тогтоох судалгааны үр дүнг танилцуулсан болно. Судалгаанд Улаанбаатар хотын найман дүүрэг, зургаан аймгийн 22 сумын нийт 1360 айл өрхөөс бүрдсэн 170 анхан шатны нэгжүүд хамрагдсан<sup>1</sup>. Түүврийн тархалтыг доорх хүснэгтэд харуулав:

<sup>1</sup> Үр дүнгүүд нь 18 ба түүнээс дээш насны 1,360 насанд хүрэгчдээс авсан ганцаарчилсан ярилцлага дээр суурилсан байгаа. Нийт улсын насанд хүрэгчдийн түүвэрт тулгуурласан үр дүнгийн хувьд түүврийн алдааны хязгаар  $\pm 1.6$  хувиас ( $p = 10$  хувь бол,  $1-p = 90$  хувь)  $\pm 2.6$  хувь ( $x = 40$  хувь бол,  $1-p = 60$  хувь) байх ба 95%-ийн итгэлийн түвшинд байна. Түүврийн алдаанаас гадна, асуултын үг хэллэгт болон санал асуулга авах бодит хүндрэлүүд нь судалгааны гол үр дүнд алдаа болон нөлөөлөл үзүүлж болох юм.


ХҮСНЭГТ 1: ТҮҮВРИЙН ТАРХАЛТ

Бүс	Хот/Аймаг	Дүүрэг/Сум	Судалгаа авсан өрхүүд
	Улаанбаатар		560
		Хан-Уул	56
		Баянзүрх	128
		Сүхбаатар	65
		Чингэлтэй	72
		Баянгол	88
		Сонгинохайрхан	119
		Налайх/Багануур	32
	Аймагууд		800
Баруун Бүс	Увс		200
		Улаангом (төв сум)	80
		Түргэн	24
		Сагил	32
		Зүүнговь	32
		Хяргас	32
Хангайн Бүс	Архангай		120
		Эрдэнэбулган (төв сум)	56
		Их Тамир	32
		Батцэнгэл	32
	Өвөрхангай		160
		Арвайхээр (төв сум)	56
		Бат-Өлзий	40
		Баянгол	32
		Тарагт	32
	Төвийн Бүс	Дундговь	
		Сайнцагаан (төв сум)	48
		Гурвансайхан	32
		Дэлгэрцогт	24
Төв		120	
		Зуунмод (төв сум)	56
		Аргалант	20
		Баянхангай	20
		Лүн	24
Зүүн бүс		Хэнтий	
		Хэрлэн (төв сум)	40
		Батноров	32
		Цэнхэрмандал	24
		Дүн	1360

## 1. ҮНДСЭН АСУУДЛУУД

Судалгаанд оролцогчдын тодорхойлж байгаагаар Монгол улсад тулгарч буй гол асуудлууд эдийн засгийн тогтворгүй байдлыг харуулж байна. Тэргүүлж буй долоон асуудлын зургаа нь үндэсний болон өрхийн эдийн засагтай холбоотой байна. Энэ хоёр асуудал хоорондоо нягт хамааралтай байдаг. “Үндэсний эдийн засаг” гэсэн бүлэг 2013 оны 3 дугаар сард 0.5 хувь байсан бол 2015 оны 4 дүгээр сард 10.2 хувь болж огцом өсөж гуравдугаар байр руу шилжжээ. Экологийн түвшин харин буурсан байна. Инфляцын түвшин 2013 оны 9 дүгээр сард хамгийн өндөр байсан бол одоо буурах шатандаа явж байна.


Зураг 1.1: Үндсэн асуудлууд (1 сонголт хийнэ)




2012 оны 11 дүгээр сараас 2013 оны 9 дүгээр сарын хооронд ажилгүйдлийн түвшин буурсан ч үндсэн асуудлын зэрэглэлээрээ өссөн байна (Хүснэгт 1.2). Үүнийг эдийн засгийн үйл ажиллагаа хумигдаж ажлын байр багасч байгаатай холбож үзэж болно. Төрийн байгууллагууд ч мөн төрийн албан хаагчдын тоог нэлээд их хэмжээгээр бууруулсан билээ.

Сүүлийн судалгаагаар авлига, хээл хахуулийн асуудал харьцангуй тогтвортой байна. Гэвч урт хугацаанд авч үзвэл авлига, хээл хахуулийн үзүүлэлт 2006 оны 28.8 хувиас сүүлийн судалгаагаар 8 хувь болж их хэмжээгээр буурсан байна (Хүснэгт 1.3). Нөгөө талаас судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь 2006 оноос хойш тогтвортойгоор “авлига манай улсад тогтсон заншил болсон” гэдэгтэй санал нийлдэг эсвэл бага зэрэг санал нийлдэг хэвээрээ байна (Зураг 1.4). Эндээс авлигын зарим хэлбэрүүд нь өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болсон учраас амархан арилах боломжгүй гэсэн үзэл өсөн нэмэгдэж байгаа нь харагдаж байна.


Зураг 1.2: Ажилгүйдэл



Зураг 1.3: Авлига



Зураг 1.4: Авлига манай улсад тогтсон заншил болсон



## 2. СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДЛЫН ХҮЛЭЭЛТ

Удахгүй болох 2016 оны УИХ-ын сонгуультай холбоотой улс төрийн үйл ажиллагаа хэдийнээ идэвхжсэн байна. Санал тоолох систем, сонгуулийн тойрог болон сонгогчдын оролцооны тухай олон нийт ихээр маргаж байна. Өнгөрсөн сонгуулиудад олон зөрчил гарч байсан учраас олон нийт эдгээр асуудлуудад болгоомжтой ханддаг нь ажиглагдсан.

Оролцогчид кампанит ажлын санхүүжилтын тухайд шударга, ил тод байна гэсэн хамгийн бага хүлээлттэй байсан (Зураг 2.1б)<sup>2</sup>. Судалгаанд оролцогчдын талаас бага зэрэг илүү хувь (53 хувь) нь кампанит ажлын санхүүжилт “огтхон ч” шударга, ил тод байна гэж үзсэнгүй.

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (60 хувь) сонгуулийн бэлтгэл үе шат болох сонгогчдын бүртгэл, ажиглагчдын багийн бүрдүүлэлт зэрэг нь “бага хэмжээгээр” ил тод байсан эсвэл “огтхон ч” ил тод биш гэж үзсэн (Зураг 2.1а). 57 орчим хувь нь сонгуулийн хэсгүүд дэх санал тоололтын ил тод байдлыг сөргөөр үнэлсэн (Зураг 2.1г), талаас бага зэрэг илүү хувь нь (51 хувь) сонгуулийн эцсийн үе шат болох - Сонгуулийн Ерөнхий Хороо мэдээллийг нэгтгэн үр дүнг тайлагнах байдлыг “бага хэмжээгээр” шударга эсвэл “огтхон ч” ил тод, шударга биш гэж үзсэн байна (Зураг 2.1д).

Сонгуулийн кампанит ажлын шударга, ил тод байдлыг үнэлж байх нь ажлыг илүү үр дүнтэй болгодог ч оролцогчдын дөрөвний нэг нь энэ үйл явцыг огтхон ч нь ил тод биш гэж харж байна (Зураг 2.1в). Энэхүү харьцангуй зөрөг үнэлгээ нь бусад үе шатуудыг бодвол сонгуулийн кампанит ажлын үйл явц нь олон нийтэд илүү нээлттэй байдагтай холбоотой байж болох юм.

Зураг 2.1: Ер нь сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? (Бодит %)

а)




<sup>2</sup> Хүчинтэй %: “мэдэхгүй” болон “хариугүй” гэсэн сонголтуудыг хассан тооцоолол.


б)



в)




г)




УИИ.МН  
СУДАЛГААНЫ САН

д)




Гэсэн хэдий ч тодорхойгүй хариултуудын үр дүнг<sup>3</sup> нэгтгэж үзэх үед кампанит ажлын санхүү хэсэгт “мэдэхгүй” хэмээн хариулсан оролцогчдын хувь хамгийн өндөр байсан (Зураг 2.2). Судалгаанд оролцогчдын дөрөвний нэг нь (23.1 хувь) асуултанд хариулж чадахгүй байсан. Судалгаанд оролцогчдын мэдэгдэхүйц хувь нь сонгуулийн явцын бэлтгэл болон санал тоолох үе шатын талаар ямар нэгэн бодолгүй эсвэл тодорхой бус байдал илэрхийлсэн. Үүнээс гадна дундаж үзүүлэлтүүдийг авч үзвэл сонгуулийн сурталчилгааны санхүүжилт болон сонгуулийн бэлтгэлийн үе шат нь шударга, ил тод байдлын хувьд хамгийн доод үнэлгээтэй байна (Зураг 2.3).

Зураг 2.2: Ер нь сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ?



<sup>3</sup> Тодорхойгүй хариултууд: “хэлж мэдэхгүй” болон “хариулаагүй”

Зураг 2.3: Сонгуулийн үе шат тус бүрийн хариултын дундаж утга (1-ээс = “Огт үгүй” 4= “Их хэмжээгээр” хүртэл)




### 3. АВЛИГЫН ТҮВШИН

2015 оны 4 дүгээр сарын байдлаар авлига хувийн амьдрал болон бизнесийн орчинд нөлөөлөх нөлөөллийн талаар олон нийтийн санал бодол 2014 оны 3 дугаар сараас нэг их өөрчлөгдөөгүй хэвээр байна. Хувийн амьдралд нөлөөлөх хариултуудын дундаж утга хоёр орчим буюу авлигын нөлөө “бага” байна. 2006 оноос хойш энэ үнэлгээ бага зэрэг сайжирсан нь өмнөх судалгаагаар авлигын эсвэл хээл хахуулийн мэдэгдсэн тохиолдлууд буурсантай холбож болох юм.

Бизнесийн орчинд авлигын нөлөөлөх дундаж утга гурав орчим байгаа нь “дунд зэрэг” нөлөөтэй гэсэн үг. Хамгийн өндөр нөлөөлөл улс төрийн амьдралд байна гэж оролцогчид хариулжээ. 2006 оноос эхлэн авлига бизнес болон улс төрийн орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ сонгуулийн мөчлөгийг даган бага зэрэг хэлбэлзсэн.

Зураг 3.1: Авлигын нөлөө





Судалгаанд оролцогчдын жагсаасан хамгийн их авилгад автсан байгууллагын жагсаалтад зарим өөрчлөлт ажиглагдсан. 2010 оны 3 дугаар сард, нэг удаа, хамгийн их авилгад автсан таван байгууллагуудын жагсаалтын тав дахь байранд УИХ байсан. Дараагаар янз бүрийн байгууллагууд эхний тавд орж байсан (Хүснэгт 3.1).

2015 оны 4 дүгээр сарын хувьд эхний таван байранд төр засгийн байгууллагууд давамгайлсан нь онцлог байна. Хэдийгээр Газрын асуудал эрхэлсэн албад тэргүүлэх байр сууриа хэвээр хадгалж байгаа ч улс төрийн намууд хоёр дугаар байр уруу шилжсэн байна.

Судалгаа хийх зорилгоор 2013 оны 3 дугаар сараас 2014 оны 3 дугаар сарын хооронд, “уул уурхай” гэсэн ангилалыг “уул уурхайн төрийн удирдлага” болон “уул уурхайн салбар дахь хувийн компаниудын” гэж хуваасан. 2015 оны 4 дүгээр сард бид “уул уурхай” гэсэн анхны ангилалыг эргэж сэргээсэн ба одоо гурав дугаар байранд байна. Энэ нь зөвхөн 2009 оны 9 дүгээр сараас бусад үед буюу 2007 оноос 2012 оны хооронд хоёр дугаар байраа хэвээр хадгалсан байсан.

2015 онд анх удаа “Засгийн газар” эхний тав дотор орж байна. “Засгийн газар” дөрөв дэх байранд жагсаж дараагаар “УИХ/хууль тогтоох байгууллага” байна. Энэ нь улс төрийн байгууллагуудад олон нийтийн итгэх итгэл нэлээн буурсныг харуулж байна.

Хүснэгт 3.1: Авлигад их автсан байгууллага

Хугацаа	1-т	2-т	3-т	4-т	5-т
3 сар 2006	Газрын Алба	Гааль	Уул уурхай	Шүүх	Цагдаа
9 сар 2006	Газрын Алба	Гааль	Уул уурхай	Шүүх	Цагдаа
3 сар 2007	Газрын Алба	Гааль	Уул уурхай	Шүүх	Бүртгэл лиценз
9 сар 2007	Газрын Алба	Уул уурхай	Гааль	Бүртгэл лиценз	Шүүх
3 сар 2008	Газрын Алба	Уул уурхай	Гааль	Бүртгэл лиценз	Шүүх
9 сар 2008	Газрын Алба	Уул уурхай	Гааль	Шүүх	Прокурор
3 сар 2009	Газрын Алба	Уул уурхай	Шүүх	Гааль	Прокурор
9 сар 2009	Газрын Алба	Шүүх	Цагдаа	Прокурор	Уул уурхай
3 сар 2010	Газрын Алба	Уул уурхай	Улс төрийн Намууд	Гааль	Парламент, хууль тогтоох байгууллага
9 сар 2010	Газрын Алба	Уул уурхай	Шүүх	Гааль	Улс төрийн намууд
4 сар 2011	Газрын Алба	Уул уурхай	Шүүх	Гааль	Улс төрийн намууд
11 сар 2012	Газрын Алба	Уул уурхай	Орон нутгийн худалдан авалт тендер	Мэргэжлийн хяналтын газар	Улс төрийн намууд
3 сар 2013	Газрын Алба	Төрийн өмчийн уул уурхай	Орон нутгийн худалдан авалт тендер	Улс төрийн намууд	Гааль
9 сар 2013	Газрын Алба	Төрийн өмчийн уул уурхай	Орон нутгийн худалдан авалт тендер	Улс төрийн намууд	Уул уурхайн хувийн компаниуд
3 сар 2014	Газрын Алба	Төрийн өмчийн уул уурхай	Орон нутгийн худалдан авалт тендер	Шүүх	Гааль
4 сар 2015	Газрын Алба	Улс төрийн намууд	Уул уурхай	Засгийн газар	Парламент/Хууль тогтоох байгууллага

Төрөл бүрийн байгууллага дахь авлигын үнэлгээний дундаж түвшинг сайтар шинжилснээр ихэнх дундаж нь гурав гэсэн оноотой байна (Зураг 3.2). Судалгаанд оролцогчид банкны салбарыг авлигад бага хэмжээгээр автсан гэж үзжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь газрын асуудал эрхэлсэн албадыг авлигад ихээхэн автсан гэж үзсэн тул тэрээр эхний байранд байна.

Зураг 3.2: Авлигын цар хүрээ (1-ээс = “огт үгүй” 5= “маш ихээр” хүртэл)



Задлаад харвал судалгаанд оролцогчдын дийлэнх нь эдгээр байгууллагуудын ихэнх нь дунд зэрэг, их хэмжээгээр, эсвэл авлигад маш их автсан гэж үзжээ (Зураг 3.3). Авлигын цар хүрээний энэхүү үнэлгээ нь хамгийн өндөр буюу судалгаанд оролцогчдын 81.4 хувиас газрын асуудал эрхэлсэн албад болон хамгийн бага буюу судалгаанд оролцогчдын 39.6 хувийн банк, санхүүгийн байгууллагууд байна.


Зураг 3.3: Авлигын цар хүрээ



<sup>4</sup> Судалгаанд оролцогчдоор тодорхой салбар буюу байгууллагууд дахь авлигын түвшинг үнэлүүлдэг. 1-5 оноо нь огт авлигагүйгээс маш их авлигатай болохыг илэрхийлнэ. Үнэлгээний дундаж гэдэг нь байгууллагад өгсөн 1-5 онооны дундаж болно.

Орон нутгийн судалгаанд оролцогчдыг Улаанбаатар хотын оролцогчдоос салгаж авч үзэхэд зарим нэг ялгаа ажиглагдсан. Улаанбаатар хотын оролцогчид дээрх байгууллагууд дахь авлигыг орон нутгийн оролцогчдоос илүү өндрөөр үнэлсэн. Эдгээр байгууллагуудын дунд хамгийн их ялгаатай нь татварын алба буюу зөрүү нь 0.44 (Зураг 3.4). Орон нутаг-УБ гэсэн хуваагдалд мэдэгдэхүйц ялгаатай бусад дөрвөн байгууллага нь 0.39-аас 0.43 хүртэл зөрүүтэй Мэргэжлийн Хяналтын Газар, улс төрийн намууд, бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлдэг албад болон орон нутгийн ханган нийлүүлэх тендерууд байна. Улаанбаатар хотын оршин суугчид хэвлэл мэдээлэл болон үйлчилгээний илүү хүртээмжтэй байх нь авлигын түвшинг өндрөөр үнэлэх шалтгааны нэг байж болох юм.


Зураг 3.4: Улаанбаатар/Орон нутаг гэсэн үнэлгээ



#### 4. АВЛИГЫН ЧИГ ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ


Судалгаанд оролцогчдын авлигын түвшний чиг хандлагын үнэлгээ нь 2006-гаас 2014 оны хооронд тогтвортой сайжирч байгааг харуулсан. Авлигын түвшин буурч байгаа гэсэн итгэл үнэмшил 2013 оны 9 дүгээр сар болон 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр байсан боловч 2015 оны 4 дүгээр сарын судалгаагаар энэхүү итгэлд томоохон өөрчлөлт гарсан (Зураг 4.1). 2014 оны 3 дугаар сард судалгаанд оролцогчдын 39.9 хувь авлигын түвшин тодорхой хэмжээгээр нэмэгдсэн гэж үзэж байсан бол 2015 оны 4 дүгээр сард энэ тоо 59 хувь болж өссөн.

Зураг 4.1: Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?



Ирэх гурван жилд авлигын түвшин буурна гэсэн итгэл буурчээ (4.2-р зураг). 2013 оны 9 дүгээр сар болон 2014 оны 3 дугаар сард судалгаанд оролцогчдын тавны нэг орчим нь авлигын түвшин нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байсан (20.4 хувь ба 23.4 хувь тус тус). 2015 оны 4 дүгээр сард судалгаанд оролцогчдын гуравны нэг нь авлига өснө гэж үзжээ (35.2 хувь). 2013 оны 9 дүгээр сар болон 2014 оны 3 дугаар сард судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь авлигын түвшин буурна гэсэн хүлээлттэй байсан (52.5 хувь ба 45.8 хувь тус тус) бол 2015 оны 4 дүгээр сард зөвхөн дөрөвний нэг нь авлигын түвшин буурна гэж найдаж байна (27.4 хувь).

Зураг 4.2: Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?



## 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ


Авлигын эсрэг тэмцэхэд саад учруулж буй хүчин зүйлүүдийг судлах үед сөрөг болон эерэг хандлагуудын аль аль нь харагдсан (Зураг 5.1). Эерэг талаар 2012 оны 11 дүгээр сард хамгийн тэргүүнд “асуудлыг хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл” гэсэн хүчин зүйл байсан. Энэ хандлага тэргүүлэх байр сууриа 2014 оны 3 дугаар сар хүртэл хадгалсан боловч түүний дундаж утга судалгааны жилүүдийн турш 3.45-аас 3.12 болж буурсан. Бага хэмжээний авлигын тохиолдлууд судалгааны үеэр аажмаар буурсантай холбоотой байж магадгүй юм.

Бусад хүчин зүйлсүүд судалгааны жилүүдийн турш хэлбэлзэж байна. “Авлигатай тэмцэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл нь боловсронгуй биш” гэсэн хариултын дундаж үзүүлэлт 2012 оны 11 сард 3,28-аас 2013 оны 9 дүгээр сард 3.05 хооронд байсан бол 2015 оны 4 дүгээр сард эргэж 3.13 болж авлигатай тэмцэхэд саад учруулж буй хамгийн өндөр үзүүлэлттэй хүчин зүйл болсон.

“Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад улс орны түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй” гэсэн хүчин зүйл мөн есч гуравдугаар байранд оров. “Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад орон нутгийн түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй” хүчин зүйл бага зэрэг доогуур буюу тав дахь байранд байна.

Эерэг хандлагуудын дунд “хууль сахиулах байгууллагууд дахь авлига” 2012 оны 11 дүгээр сард 3.41-аас 2015 оны 4 дүгээр сард 3.04 болж тасралтгүй буурсныг бид ажигласан.

Зураг 5.1: Авлигатай тэмцэхэд саад болдог хүчин зүйлс (1-ээс = “огт үгүй” 4= “ихээр” хүртэл)




2012 оны 11 дүгээр сараас хойш судалгаанд оролцогчид тогтмол “хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах” нь авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй арга гэж сонгож байсан (Зураг 5.2). Үүний дараа “хуулиа тогтвортой хэрэгжүүлэх” гэдэг хариулт байна. Энэ нь ихэнх хууль тогтоомж болон түүнийг хэрэгжүүлэлт тогтвортой биш байдагтай холбоотой байж болох юм.

“Иргэдийн зүгээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгох” гэсэн хариулт жилээс жилд буурч 2015 оны 4 дүгээр сард 11.9 хувь болсон. Харин “төрийн зүгээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгох” нь илүү дэмжигдсээр 15.4 хувьд хүрсэн. “Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх” нь өнгөрсөн жил 9.9 хувь болж нэлээд буурсан. Иргэний болон олон нийтийн санаачилгыг ерөнхийдөө дэмжихгүй байгаа нь судалгаанд оролцогчид тэдгээрийг үр дүнтэй байна гэдэгт итгэл үнэмшил бага байдагтай холбоотой байж болох юм.

“Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх” нь 2012 оны 11 дүгээр сараас хойш тогтвортой өсөх чиг хандлагатай байсан боловч 2015 оны 4 дүгээр сард 8.3 хувь болж огцом буурсан. Өмнөх өсөлт нь олон нийтийн инфляцийн талаарх санаа бодолтой холбоотой байсан ба цалин нэмэх эрэлт хүсэлтийг бий болгож байсан (Зураг 1.1). Судалгаанд оролцогчдын хамгийн сүүлийн үндсэн асуудлуудын эрэмбэнд “инфляци”-ийн бууралт болон “үндэсний эдийн засаг”-ийн өсөлт нөлөөлсөн бололтой.


Зураг 5.2: Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам





Бага зэрэг өөрчлөлтүүдийг эс тооцвол 2012 оны 11 дүгээр сараас хойш авлигын эсрэг тэмцлийг удирдах байгууллагын талаарх судалгаанд оролцогчдын үзэл бодол үндсэндээ өөрчлөгдөөгүй хэвээр байна. Өндөр оноогоор хамгийн тэргүүний сонголт нь АТГ бөгөөд 2015 оны 4 дүгээр сард судалгаанд оролцогчдын гуравны нэг гаруй (37.8 хувь) нь сонгосон байна. “Засгийн газар” 2014 оны 3 дугаар сараас буурч 14.2 хувьтайгаар хоёрдугаар байранд зогсож байна. “Иргэний нийгэм” гуравт байна.

Зураг 5.3: Авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (1 сонголт хийнэ.)




Одоогийн Засгийн газар өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ? Энэхүү асуултанд олон нийтийн санал бодол 2013 оны 9 дүгээр сараас сөргөөр эргэж эхлэв (Зураг 5.4). Үндэсний эдийн засгийн ерөнхий байдал болон холбогдох засаглалын асуудлуудаас гадна ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн Засгийн газрын үнэлгээ сүүлийн санал асуулгаар тодорхой хэмжээгээр буурсан. 2013 оны 9 дүгээр сард судалгаанд оролцогчдын 39.6 хувь нь ерөнхий сайд Н.Алтанхуягийн Засгийн газар өмнөх ерөнхий сайд С.Батболдын Засгийн газраас илүү сайн ажиллаж байсан гэж үзэж байсан. Харин 2015 оны 4 дүгээр сард судалгаанд оролцогчдын ердөө 7.2 хувь нь ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн Засгийн газар авлигын асуудлыг сайн шийдвэрлэж байна гэж үзсэн.

Зураг 5.4: Таны бодлоор одоогийн Засгийн газар өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ?




Судалгаанд оролцогчид авлигатай тэмцэх үндсэн байгууллага буюу АТГ-ын үнэлгээн дээр мөн сөрөг хандлага гаргаж ирсэн (Зураг 5.5 ба 5.6). АТГ-ын үйл ажиллагааны сөрөг үнэлгээ нь 2013 оны 9 дүгээр сард 32.1 хувиас 2014 оны 3 дугаар сард 37.3 хувь болж мөн 2015 оны 4 дүгээр сард 45.5 хувь болж өсчээ. Үүнтэй холбоотойгоор АТГ-т итгэх итгэл 2013 оны 9 дүгээр сард 46.5 хувиас 2014 оны 3 дугаар сард 45.7 хувь болж мөн 2015 оны 4 дүгээр сард 39.2 хувь болж буурсан байна.

Зураг 5.5: Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг Та хэрхэн үнэлж байна вэ?




Зураг 5.6: Авлигатай тэмцэх газарт Та хэр зэрэг итгэдэг вэ?






2010 оны 3 дугаар сараас 2014 оны 3 сард АТГ-ыг хараат бус хууль сахиулах байгууллага гэж үзсэн оролцогчдын тоо 2010 оны 3 дугаар сард судалгаанд оролцогчдын тавны нэгээс (21.7 хувь) 2014 оны 3 дугаар сард гуравны нэг (34.7 хувь) болж нэмэгдэж байсан (Зураг 5.7). 2015 оны 4 дүгээр сард нэлээдгүй өөрчлөгдөж олон нийтийн санал бодол 2010 оны 3 дугаар сарын түвшинд эргэн очжээ.

Зураг 5.7: Та Авлигатай тэмцэх газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддагт итгэдэг үү?




АТГ-ын үнэлгээтэй холбож болох өөр нэгэн хүчин зүйл бол төрийн албан хаагчдын авлигын гэмт хэрэгт холбогдсон байдал юм. Эдгээр хэргүүдийн талаарх олон нийтийн мэдлэг 2013 оны 9 дүгээр сард 51.6 хувиас 2015 оны 4 дүгээр сард 40.4 хувь болж буурсан (Зураг 5.8).

Зураг 5.8: Авлигын эсрэг хууль батлагдсанаас хойш хуулийн хүрээнд аль нэг албан тушаалтан шийтгүүлсэн тухай Та сонссон уу?




2010 оны 3 дугаар сараас 2011 оны 4 дүгээр сарын хооронд судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь авлигын тухай мэдээлэл өгөх утас байгааг мэднэ гэжээ. Хугацаа өнгөрөхийн хэрээр энэхүү тоо судалгаанд оролцогчдын дөрөвний нэг болж буурсан бөгөөд хамгийн сүүлийн судалгаагаар тэр түвшинд хэвээр байна (Зураг 5.9).

Зураг 5.9: Та авлигын талаар мэдээлэл авах утас ажиллаж байгааг мэдэх үү?



2012 оны 11 дүгээр сараас хойш судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь АТГ мэдээлэгчийг нууцалсан мэдээлэл хүлээн авдаг байсан бол авлигын талаар мэдээлэх хүсэлтэй гэсэн байна (Зураг 5.10). Сүүлийн судалгаагаар энэ тоо бага зэрэг буурсан хэдий ч тайлагнах хүсэлгүй хүмүүсийн тоо тавны нэг хүрэхгүйгээс бараг гуравны нэг болж мэдэгдэхүйц өссөн. Учир нь ямар нэг үзэл бодол илэрхийлээгүй оролцогчдын тоо багассан.

Зураг 5.10: Хэрвээ Авлигатай Тэмцэх Газар нэр хаяггүй мэдээлэл хүлээж авна гэвэл Та авлигын талаар мэдээлэл өгөх үү?



## 6. АВЛИГЫН ЭСРЭГ САНААЧЛАГА

Авлигыг бууруулах төрийн байгууллагуудын санаачлагууд дунд судалгаанд оролцогчид ач холбогдол бөгөөд үр нөлөө аль алины хувьд “шинэ техник, технологи нэвтрүүлэх”-ийг хамгийн өндрөөр үнэлсэн байна (Зураг 6.1 ба 6.2). Судалгаанд оролцогчдын гуравны хоёр (71.6 хувь) орчим нь үүнийг “ихээхэн” эсвэл “маш их” ач холбогдолтой, оролцогчдын талаас илүү (62.2 хувь) нь “ихээхэн” эсвэл “маш их” үр дүнтэй гэж үнэлсэн байна.

Шинэ технологи гэдэг нь ерөнхийдөө мэдээллийн автоматжуулалт гэсэн утгатай тул судалгаанд оролцогчдын прагматик хандлагыг харуулж байна. Хүнээр үзүүлж буй үйлчилгээ болон тэдний авлига авах боломжийг үгүй болгох зэрэг олон нийтийн үйлчилгээний автоматжуулалтын<sup>5</sup> үр ашгийг хүн бүр ойлгож байгаа.

Авлигын эсрэг үр дүнтэй санаачилгын 2-т Шилэн дансны хууль оржээ. Судалгаанд оролцогчдын талаас нэлээд их хувь нь (62.2 хувь) энэ хэмжүүрийг “ихээхэн” эсвэл “маш их” чухал гэж үзсэн. Талаас арай бага хувь нь (41.8 хувь) түүнийг “ихээхэн” эсвэл “маш их” үр дүнтэй байна гэж бодсон.

Бусад санаачилгуудын дунд оролцогчдын бараг тал хувь нь (51.7 хувь) төрийн албан хаагчдын байнгын орлого буюу хөрөнгө орлогын мэдүүлгийг танилцуулж байх нь “ихээхэн” эсвэл “маш их” ач холбогдолтой гэж үзсэн бол зөвхөн дөрөвний нэг (26.3 хувь) нь энэ арга хэмжээг “ихээхэн” эсвэл “маш их” үр дүнтэй байна гэж үзсэн.

Иргэний нийгмийг ач холбогдол болон үр өгөөж багатай гэж үзэх нь олон нийт иргэний нийгэмд үл итгэх үзэл бодол их байгаатай холбоотой. Гэсэн хэдий ч энэ хандлага өөрчлөгдөж байгаа ба энэ нь удаан үйл явц юм.

Сонгуулийн хуулийн шинэчлэлийн хувьд судалгаанд оролцогчдын гуравны нэгээс илүү хувь (41.7 хувь) нь үүнийг “ихээхэн” эсвэл “маш их” чухал гэж үзсэн бол тавны нэг хүрэхгүй хувь (19 хувь) нь үүнийг “ихээхэн” эсвэл “маш их” үр дүнтэй гэж үзсэн байна. Олон нийтийн үл итгэх байдал нь сонгуулийн хуульд байнга өөрчлөлт орж байдагтай холбож болно.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>5</sup> Төрийн Үйлчилгээний Цахим машин

Зураг 6.1: Дараах арга хэмжээнүүд хэр ЧУХАЛ гэж та бодож байна вэ?



Зураг 6.2: Дараах арга хэмжээнүүдийг хэр зэрэг ҮР ДҮНТЭЙ байна гэж та бодож байна вэ?




## 7. ШУДАРГА ХАНДЛАГА

Авлигатай тэмцэх чиг хандлага нь төрийн үйлчилгээг хүртэх үед шударгаар хандах чиг хандлагыг бодвол илүү эерэг байдаг.


Зарим нэг хэлбэлзлүүдийг эс тооцвол сүүлийн үеийн судалгаанд оролцогчдын тал хувь нь боловсролын тогтолцоог шударга гэж үзэж байна (2015 оны 4 дүгээр сар - 51.9 хувь). Үүнээс илүүтэйгээр энэхүү ойлголт цаг хугацааны туршид нэлээд бэхжсэн. Эрүүл мэндийн тогтолцоонд цаг хугацааны явцад мөн зарим нэг ахиц гарсан ба гуравны нэгээс илүү оролцогчид шударга хандлагыг хүлээж байна (2015 оны 4 дүгээр сар - 43.2 хувь). Энэ үзүүлэлт 2010 оны 3 дугаар сараас тогтвортой өсч 2013 оны 3 дугаар сард эдгээр ангилалуудад ижил түвшин харагдсан (Зураг 7.1).

Зураг 7.1: Боловсрол болон эрүүл мэндийн салбарын шударга хандлага




Шүүхийн тогтолцоо болон хууль сахиулах байгууллагын талаар судалгаанд оролцогчид доогуур үнэлгээтэй байсан хэдий ч цаг хугацааны явцад мөн ахиц дэвшил гарч байна. 2010 оны 3 дугаар сард судалгаанд оролцогчдын дөрөвний нэг хүрэхгүй хувь нь эдгээр байгууллагуудыг шударга харилцаатай гэж үзэж байсан бол сүүлийн судалгаагаар ойролцоогоор гуравны нэг болсон байна (Зураг 7.2). Эдгээр байгууллагуудын шударга гэсэн хамгийн өндөр үнэлгээ нь 2015 оны 4 дүгээр сард байна.

Зураг 7.2: Шүүхийн тогтолцоо болон хууль сахиулах байгууллагын шударга хандлага



Орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагуудын тухайд сүүлийн судалгаагаар оролцогчдын үзэл бодлын ихээхэн ялгаа харагдсан. Орон нутгийн захиргаа шударга харилцах хүлээлт 2013 оны 9 дүгээр сард 41.3 хувиас 2014 оны 3 сард 48.8 хувь болж өссөн ба 2015 оны 4 дүгээр сард хамгийн өндөр болох 52 хувь болсон. Харин төрийн захиргааны төв байгууллагуудын шударга харилцах хүлээлт сүүлийн үеийн судалгаагаар буурсан байна. Оролцогчдын шударга харилцах хүлээлт 2013 оны 9 дүгээр сард 39.5 хувиас 2014 оны 3 дугаар сард 47.4 хувь болж өссөн хэдий ч 2015 оны 4 дүгээр сард 43.8 хувь болж буурсан.

Зураг 7.3: Орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагуудын шударга хандлага




## 8. ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

2012 оны 11 дүгээр сард энэхүү ойлголтыг нэвтрүүлснээс хойш дээд түвшний авлигын (ДТА) тухай хүн амын үзэл бодол тогтож эхэлсэн. Санал болгосон зургаан тодорхойлолтоос “өндөр түвшний төрийн албан тушаалтнууд оролцсон хэрэг” болон “улс төрийн ихээхэн ашиг сонирхлыг хамарсан хэрэг” гэдгийг судалгаанд оролцогчид хамгийн илүүд үзсэн (Зураг 8.1). Эдгээрийн дараа “улсад их хэмжээний хохирол учруулсан хэрэг” орсон. (Үнэндээ “улс орны хохирол”-ыг хэмжиж байгаа тул энэхүү гурав дахь хувилбар нь ДТА-ын хамгийн ашигтай албан ёсны тодорхойлолт юм. Өмнөх судалгаагаар ДТА-д хамаарах хээл хахуулийн хэмжээг оролцогчдоор үнэлүүлэх оролдлогоор төрөл бүрийн үр дүнгүй хариултуудыг олж авсан.)

Эдгээр ажиглалтууд дээр үндэслэн ДТА гэдгийн түгээмэл ойлголтыг тодорхойлж болох юм. Дийлэнх оролцогчдын хувьд “өндөр түвшний төрийн албан тушаалтнууд” гэдэгт улс төрчид, “улс төрийн ихээхэн ашиг сонирхол” гэдэгт улс төрийн болон хувийн ашиг сонирхлыг холбож үзэж байна. Эцэст нь ДТА гэдгийг “улсад их хэмжээний хохирол учруулах улс төрийн ашиг сонирхлыг хамруулсан тохиолдлууд” гэж тодорхойлж болно.

Зураг 8.1: Дээд түвшний авлигын тодорхойлолт



ДТА-ын шалтгаануудыг авч үзвэл оролцогчдын тавны нэг орчим нь (19.5 хувь) төр засгийн өндөр түвшин дэх ил тод байдал дутагдалтай гэж үзсэн бол дараагаар нь “улс төр болон бизнесийн ашиг сонирхлын нэгдэл” гэжээ (19.1 хувь). Өөр нэг дурьдсан шалтгаан нь “Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын томоохон компаниуд авлигын аргыг хэрэглэх нь түгээмэл” (18.2 хувь) гэж хариулжээ.


Энэ нь Монголын хүн амын нэг хэсэг нь олон улсын томоохон төслүүдийг сөргөөр хүлээн авдаг хандлагыг зарим талаар тайлбарлаж байна. Олон нийтийн бодож байгаагаар эдгээр төслүүд нь ДТА-ын тэргүүний гурван шалтгаан болох: засгийн газрын ил тод байдал хангалтгүй, улс төр болон бизнесийн нэгдэл мөн гадаадын томоохон хөрөнгө оруулагчдын авлигажсан нөлөө зэргийг нэгтгэсэн байдлаар хийгддэг.

Зураг 8.2: Дээд түвшний авлига Монголд яагаад оршиж байна вэ?




ДТА-ын тухай оролцогчдын үзэл бодол өмнөх судалгаанаас нэг их өөрчлөгдөөгүй. Хоёр жилийн турш үнэлсэний эцэст судалгаанд оролцогчдын ойролцоогоор тэн хагас нь ДТА “нэлээд хэмжээний” байна гэж үзсэн (Зураг 8.3). ДТА-ын бодит тохиолдлуудын талаарх мэдлэг мөн тогтвортой байна (Зураг 8.4). Дунджаар оролцогчдын тавны нэг нь ДТА-ын тохиолдлын талаар “байнга” сонсдог гэсэн байна.

Зураг 8.3: Монгол дахь ДТА-ын түвшин



Зураг 8.4: Та дээд түвшний авлигын талаар хэр их олж сонсдог вэ?






Судалгаанд оролцогчдоос тэдгээрийн мэдэх хээл хахуулийн төрлийг асуухад гуравны нэгээс илүү хувь (37.6 хувь) нь “бэлэн мөнгө”, харин дөрөвний нэгээс бага зэрэг илүү хувь (26.8 хувь) нь хахуулийн хэлбэр нь “захиргаан дахь албан тушаал” гэсэн байна (Зураг 8.5). Хоёр дахь нөхцөл байдал нь хамгийн хор уршигтай юм. Учир нь энэ нь авлигын сүлжээний үндэс суурь болдог.

Зураг 8.5: Хэрэв сонссон бол ямар хэлбэрийн авлига байсан бэ?




Судалгаанд оролцогчдын аравны нэгээс арай илүү хувь (13.1 хувь) нь ДТА тэдний гэр бүлд “маш хүчтэй” сөрөг нөлөө үзүүлж байна. Харин гуравны нэг нь (29.2 хувь) ямар ч үр нөлөөгүй (Зураг 8.6) гэж үзсэн. Энэ нь олон Монголчуудын хувьд ДТА-аас учруулах хохирол нь тэдний амьдралын бодит байдалтай холбоогүй мөн шууд олж харах боломжгүй хийсвэр зүйл хэвээр байгааг харуулж байна.

Зураг 8.6: Дээд түвшний авлига Та болон таны гэр бүлийн амьдралд хэр нөлөөлдөг вэ?




Хүн амын ихэнх нь ДТА-ын талаар мэдлэг ойлголт багатай байгаа нь үүнтэй тэмцэх аргуудын сонголтоор мөн харагдаж байна. Дээд түвшний авлигын талаар ямар ч хариултгүй эсвэл ямар ч үзэл бодлоо илэрхийлээгүй тохиолдол ерөнхий авлигаас хамаагүй их байсан (их авлига 43.2 хувь, ерөнхий авлига 0.7 хувь тус тус байна). Хэдийгээр судалгаанд оролцогчид аль аль тохиолдлуудын хувьд АТГ-ын удирдлагыг илүүд үзсэн боловч нийлбэр нь ерөнхий авлигын хувьд 37.8 хувь байхад дээд түвшний авлигын хувьд ердөө 17.7 хувь байна (Зураг 8.7 ба Зураг 5.3). Энэ нь нийт хүн ам дээд түвшний авлигатай тэмцэх хамгийн тохиромжтой байгууллагын талаар тодорхой үзэл бодолгүй байгааг харуулж байна.

Зураг 8.7: Дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (1 сонголт хийнэ.)



ДТА-тай тэмцэх арга замууд дундаас дийлэнх оролцогчид авлигатай тэмцэх хууль эрх зүйг боловсронгуй болгох, хууль сахиулах байгууллагад илүү их эрх мэдэл олгох мөн иргэний байгууллагуудын оролцоо, чадавхийг сайжруулах зэргийг илүүд үзсэн. Харин бие даасан хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дэмжих эсвэл авлигын эсрэг чанга хөтөлбөртэй улс төрийн намуудыг дэмжих нь үр дүнтэй гэдэгт маш цөөн оролцогчид итгэж байна.

Зураг 8.8: Дээд түвшний авлигатай тэмцэхэд хамгийн их үр дүнтэй арга аль нь гэж та бодож байна вэ? (Хоёр хариулт сонгох)



## 9. ӨРХИЙН ТҮВШНИЙ АВЛИГА

Өрхийн түвшний авлигад хандах олон нийтийн хандлага 2014 оны 3 дугаар сараас 2015 оны 4 дүгээр сарын хооронд хэвээр үлдсэн байна (Зураг 9.1). Судалгаанд оролцогчдын гуравны нэг гаруй хувь асуусан ч хахууль өгөхгүй гэсэн байна. Авлигын тохиолдлыг мэдээлэх хүмүүсийн тоо 2014 оны 3 дугаар сард 12.9 хувиас 2015 оны 4 дүгээр сард 15.3 хувь болж бага зэрэг нэмэгдсэн. Бусад ангилалууд их бага хэмжээгээр хэвээр үлдсэн.


Зураг 9.1: Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ?




Хариултын сонголтууд<sup>6</sup> өөрчлөгдсөний улмаас судалгаанд оролцогчид авлигыг хаана мэдээлэх тухай шууд харьцуулалт хийх боломжгүй байна. Гэсэн хэдий ч 2015 оны 4 дүгээр сараас өмнөх судалгаагаар оролцогчдын бараг тал хувь нь АТГ-т мэдээлнэ гэж хариулсан (Зураг 9.2а). 2015 оны 4 дүгээр сард судалгаанд оролцогчдын тавны нэгээс бага зэрэг илүү хувь (22 хувь) нь удирдлагад мэдээлнэ гэсэн бол 14 хувь нь Засгийн газрын 11-11 утсаар мэдэгдэнэ гэсэн байна (Зураг 9.2б).

Зураг 9.2: Хэрвээ авлигын тухай мэдэгдэх бол хаана?

а) 2015 оны 4 дүгээр сараас өмнө




б) 2015 оны 4-р сар




<sup>6</sup> 2015 оны 4-р сард “Засгийн газрын шууд утас 11-11” гэсэн сонголт хариултанд шинээр орж ирсэн (Зураг 9.2б)

Өрхийн түвшний авлигын тохиолдолд оролцох нь 2014 оны 3 дугаар сард найман хувь байснаас 2015 оны 4 дүгээр сард долоон хувь болж бага зэрэг буурсан (Зураг 9.3). Хээл хахуулийн хэв маяг 2012 оны 11 дүгээр сараас өөрчлөгдөөгүй хэвээр байна (Зураг 9.4). Судалгаанд оролцогчдын дийлэнх нь (67.4 хувь) тухайн үйлчилгээг авахын тулд хахууль төлсөн гэж хэлсэн. Хахууль өгөхийг шаардсан тохиолдлуудын тоо 2014 оны 3 дугаар сард 13.6 хувь байснаас 2015 оны 4 дүгээр сард 15.2 хувь бол бага зэрэг нэмэгдсэн байна. Захиргааны асуудлаас зайлсхийхийн тулд хахууль төлсөн тохиолдлуудын тоо сүүлийн хэдэн судалгаагаар өөрчлөгдөөгүй хэвээр үлдсэн (2015 оны 4 дүгээр сард 16.3 хувь).

Зураг 9.3: Өнгөрсөн 3 сарын хугацаанд Та эсвэл танай өрхийн гишүүн хахууль өгсөн үү?




Зураг 9.4: Таны хахууль өгөх болсон гол шалтгаан юу байсан бэ?



Өрхийн төсөв нь “ноцтой хохирсон” өрхүүдийн тоо 2013 оны 9 дүгээр сараас харьцангуй тогтвортой болж эхэлсэн. 2015 оны 4 дүгээр сард судалгаанд оролцогчдын дөрөвний нэг (25 хувь) нь төсөвт “ноцтой нөлөөлсөн” гэж хариулсан. Гэсэн хэдий ч доорх хүснэгтээс төлсөн хээл хахуулийн дундаж хэмжээ 277.000 төгрөг болж бага зэрэг буурсан нь харагдаж байна. Инфляцийг үл харгалзан энэ дүн 2014 оны 3 дугаар сард мэдээлсэн дундаж хэмжээнээс (520,000 төгрөг) хамаагүй багассан байна. Энэхүү уналт нь амьжиргааны түвшин буурч байгаатай холбоотой байж болох юм.

Зураг 9.5: Өрхийн төсөв нь “ноцтой хохирсон” өрхүүдийн хувь хэмжээ



ҮСХ		Дүн	СУДАЛГАА		
Улсын статистик мэдээ	Нийт өрхийн тоо	Нийт төлсөн хахууль (тэрбум төгрөгөөр)	Хахууль өгсөн өрхийн хувь хэмжээ	Хахуулийн дундаж хэмжээ	
2005	611,000	28.8	26%	181	3 сар 2006
2005	611,000	23.3	28%	136	9 сар 2006
2006	632,500	14.8	23%	102	3 сар 2007
2006	632,500	26	22%	187	3 сар 2007
2007	645,700	23.2	19%	180	3 сар 2008
2007	645,700	42.4	21%	298	9 сар 2008
2008	677,800	40.3	15%	397	3 сар 2009
2008	677,800	41.7	20%	308	9 сар 2009
2008	677,800	21.2	16%	195	3 сар 2010
2009	717,000	38.8	13%	416	9 сар 2010
2010	742,000	20.8	8.80%	319	4 сар 2011
2010	742,000	35.9	12.40%	391	11 сар 2012
2010	742,000	32.6	8.75%	502	3 сар 2013
2012	768,300	30.8	7.64%	525	9 сар 2013
2012	768,300	30.2	7.57%	520	3 сар 2014
2013	794,090	14.9	6.77%	277	4 сар 2015

## 10. ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Авлигын талаар олон нийтийн хандлагыг тодорхойлж буй хүчин зүйлсийн дүн шинжилгээг хийх зорилгоор авлигын төрөл хэмжээсийн тухай 17 өгүүлэмжээс бүрдэх бүлэгт үндсэн бүрэлдэхүүний дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Хүснэгт 10.1-д харуулснаар дөрвөн хүчин зүйл илэрсэн:

- Авлигын нийгмийн үр нөлөө
- Авлигатай тэмцэхэд иргэний үүрэг оролцоо
- Нийгэм дэх авлигын үндэс
- Авлигын заншлын суурь

Эхний хүчин зүйлд авлигын нийгэмд үзүүлэх үр нөлөөг тодорхойлж байгаа хувьсагчид нь тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна. Энэ хүчин зүйлийн гол хувьсагч нь “Авлигаас илүү их хохирдог жирийн ардыг бодвол шийдвэр гаргагчид авлигаас бага хохирч байгаа” явдал юм.

Хоёр дахь хүчин зүйл нь иргэний нийгэм авлигыг арилгахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн хандлагыг илэрхийлж байна. Энэ хүчин зүйлийн гол хувьсагч нь “Иргэний нийгэм авлигаас урьдчилан сэргийлж чадна” гэсэн байна.

Гурав дахь хүчин зүйл нь авлига нийгэмд байдаг шалтгаанууд юм. Зарим асуудлууд зөвхөн авлигын замаар шийдвэрлэгдэнэ. Тэргүүлэх хувьсагч нь “Хээл хахууль өгөх нь шударга бус дүрэм журмыг даван туулахад тусалдаг” гэсэн байна.

Дөрөв дэх хүчин зүйл нь хамгийн сул буюу авлигын зарим нэг заншлын үндсийг харуулж байна. Авлига нь нийгэмд гүн гүнзгий үндэстэй болохоор оршиж байна. Энэ хүчин зүйл нь хуучин уламжлалт ёс зүйн зан үйл болон шинэ гэмт хэрэг гэдгийн ойлгомжтой тодорхойлолттой хууль дээр суурилсан дүрэм хоорондын зөрчлийг тайлбарлаж чадах юм.


Хүснэгт 10.1 Олон нийтийн хандлагыг тодорхойлж буй хүчин зүйлс

Хүчин зүйл 1: Нийгэмд үзүүлэх авлигын нөлөө		Хүчин зүйл 2: Авлигын эсрэг иргэний үүрэг роль	
Сонголт	Оноо	Сонголт	Оноо
Шийдвэр гаргагчид өөрсдөө авлигаас төдийлөн хохирдоггүй, жирийн иргэд л авлигын дарамтыг илүү мэдэрч байгаа.	.687	Иргэний нийгэм авлигыг урьдчилан сэргийлж чадна.	.713
Авлигыг багасгахад иргэд өөрсдөө хариуцлагатай байх ёстой.	.642	Зөвхөн төрийн байгууллагууд л авлигыг урьдчилан сэргийлэхэд тусалж чадна.	.597
Авлигаас болж том бизнесийнхэнээс илүүтэйгээр жижиг, дунд бизнес эрхлэгчид хохирдог.	.583	Өнөөгийн улс төрийн тогтолцоо авлигыг зогсоохын тулд амжилттай тэмцэж чадаж байна.	.592
Том бизнес авлигын гол эх үүсвэрийн нэг нь.	.566	Орон нутгийн захиргааны албан хаагчид ихэнхдээ итгэл үзүүлж болохуйц, хариуцлагатай хүмүүс байдаг.	.545
Авлигын эсрэг өнөөгийн хууль үр дүнтэйгээр хэрэгжихгүй байна.	.555	Өнөөгийн нөхцөлд иргэдийн хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд авлигын эсрэг тэмцэх гол хүчин юм.	.403
Улс төрчид авлигаас тодорхой ашиг хонжоо олдог учраас бодит хэрэг дээрээ авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл байдаггүй.	.550		
Хээл хахууль өгсөн хүн түүнийг авсан хүнтэй адил гэм буруутай	.399		
Албан тушаалтнуудад хатуу ял шийтгэл оногдуулах нь авлигыг зогсооно.	.374		



Хүчин зүйл 3: Нийгэм дэх авлигын хандлага		Хүчин 4: Авлигын зуршил, зан зүйл	
Сонголт	Оноо	Сонголт	Оноо
Хээл хахууль нь зарим үед шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг	.699	Авлига манай улсад тогтсон заншил болсон.	-.349
Нийгэмд газар авсан хүнд суртлыг гэтлэн давах цорын ганц арга нь хээл хахууль өгөх явдал юм.	.580	Авлигатай тэмцэх бодлогын хэрэгжүүлэлт улс төрийн сонирхол агуулаагүй.	.617
Авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрнө.	.497	Авлига тодорхой түвшинд цаашид байсаар байх болно.	.527
Авлига манай улсад тогтсон заншил болсон.	.490	Төрийн албан хаагчид бага цалин авч байгаа нь хээл хахуулийн нэг гол шалтгаан болдог.	.516

Зураг 10.1: Хандлагыг тодорхойлох гол хувьсагчууд




## 11. ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Хүн ам зүйн дөрвөн ангиллаар - хүйс, байршил, орлого, нас - мэдээллийн шинжилгээ хийхэд бүлгүүд дэх хамгийн онцлого ялгаа нь хот болон орон нутгийн оролцогчдын дунд байсан. Хот суурин газрын оролцогчид хэвлэл мэдээллийн илүү хүртээмжтэй ба үйлчилгээ авах боломжоор илүү. Ингэснээр тэд авлигыг илүү харж, сөрөг үзэл бодол руу чиглэж мөн бүх түвшинд өөрийн санал бодлоо илүү их илэрхийлж байдаг.




Зураг 11.1: Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (Газар зүйн байршлаар)




Анх харахад хэсэг хувьсагчуудад хүйсийн зарим нэг ялгаа харагдаж байгаа боловч энэ нь ихэвчлэн эмэгтэйчүүд ямар нэгэн үзэл бодолгүй байх эсвэл шийдэмгий бус байгаагийн нөлөө юм. Эдгээр тохиолдлуудыг хассаны дараа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын ялгаа нь алдааны хязгаараас доогуур болж ямар нэгэн ач холбогдолгүй болох юм. Мөн эрэгтэй хүмүүс “огт”, “маш их” болон “их” гэсэн эрс хариултын сонголтуудыг илүүд үздэгийг анзаарч болно. Харин эмэгтэйчүүд “илүү дээр”, “зарим” болон “бага хэмжээгээр” зэрэг дундаж хариултуудыг илүүд үздэг. Гэсэн хэдий ч гол асуудал болох шууд хахууль нэхсэн тохиолдолд судалгаанд оролцогчид ямар үйлдэл хийх гэдэг дээр хүйсийн ялгаа бага байна.

Зураг 11.2: Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (Хүйсээр)



Орлогын нөлөөний хувьд боловсролтой холбоотой байдаг орлогын сонгодог байдал нь оролцогчдын дунд гарах ялгаанд үүрэг гүйцэтгэж байна. Өндөр орлоготой оролцогчид өндөр боловсролтой байх нь элбэг бөгөөд тухайн асуудлаар саналаа илүү өгөх талтай байдаг. “Би мөнгөтэй байгаа бол” гэдэг үндэслэлээр өндөр орлого нь оролцогчдыг хээл хахууль өгөх илүү сонирхолтой болгодог гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Зураг 11.3: Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (Орлогоор)



Судалгаанд оролцогчдын насны нөлөө нь тэдний идэвхитэй байдлын түвшинтэй нягт холбоотой. Дундаж насны бүлэг хамгийн идэвхтэй бөгөөд авилгын талаар илүү сөрөг үзэл бодол илэрхийлдэг. Залуу насны бүлэг ямар нэгэн үзэл бодолгүй байх хандлагатай ба социал медиа илүүтэйгээр тэдний мэдээллийн эх үүсвэр байдаг. Ахмад насны бүлэг авлигатай тулгарах үед төлөх хамгийн бага хүсэлтэй хүмүүс байна.

Зураг 11.4: Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (Насаар)



## IV. СУДАЛГААНД АШИГЛАСАН АСУУЛГА

Авлигын талаарх олон нийтийн ойлголт болон мэдлэг тогтоох судалгааны үндсэн зорилго нь Монгол улс дахь авлигын түвшинг тодорхойлоход оршино. Бид улс орон даяар 1360 гаруй хүнээс энэхүү судалгааг авч байгаа юм. Бид янз бүрийн авлигын хэлбэр болон танд тохиолдож болох өдөр тутмын авлигын талаарх таны мэдлэг туршлага, санал бодлыг судлах болно.

Таны хэрхэн хариулсаныг хэн нэгэн мэдэх боломжгүй гэдэгт Та итгэлтэй байж болно. Санал асуулгад сайн дурын үндсэн дээр оролцох бөгөөд бүх хариултын хувьд тодорхой эзэнг заахгүйгээр мэдээллийн нууцыг хадгална.

Энэхүү судалгааг амжилттай явуулахад таныг хамтран ажилласанд гүн талархал илэрхийлье. Хэрэв манай судалгаатай холбогдсон ямар нэг асуудал гарвал манай албаны 70116373 тоот утсаар лавлах боломж Танд байна. Судалгааны үр дүнг олон нийтэд өргөнөөр танилцуулах болно.

### A. Ерөнхий хэсэг

1. Таны бодлоор манай улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн хувьд өнөөдөр тулгамдаж буй хамгийн чухал асуудал юу вэ?

2. Зарим хүмүүс авлига Монголын нийгмийн амьдралын янз бүрийн хүрээнд нөлөөлж байна гэж үздэг. Таны бодлоор авлига ... хүрээнд огт нөлөөлдөггүй, бага зэрэг, тодорхой хэмжээгээр, их хэмжээгээр нөлөөлдөг вэ?

Хүрээ	Огт нөлөөлдөггүй	Бага зэрэг нөлөөлдөг	Тодорхой хэмжээгээр нөлөөлдөг	Их хэмжээгээр нөлөөлдөг	Хэлж мэдэхгүй/Хариулаагүй
2.1 Таны хувийн болон гэр бүлийн амьдралд	1	2	3	4	9
2.2 Бизнесийн хүрээнд	1	2	3	4	9
2.3 Улс төрийн амьдралд	1	2	3	4	9

3. 2016-2017 онуудад хэд хэдэн сонгууль болох гэж байна. Ер нь сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ?

	Огт үгүй	Бага зэрэг	Тодорхой хэмжээгээр	Их хэмжээгээр	Мэдэхгүй/ Хариулаагүй
3.1. Сонгуулийн бэлтгэл, Жишээ нь: сонгогчдыг бүртгэх, сонгуулийн хороод болон ажилтнуудыг бэлтгэх, гадаад дотоодын ажиглагчдыг оролцуулах гэх мэт	1	2	3	4	9
3.2. Сонгуулийн санхүүжилт	1	2	3	4	9
3.3 Сонгуулийн сурталчилгааны үе / сонгуулийн кампани	1	2	3	4	9
3.4. Санал хураалт	1	2	3	4	9
3.5. СЕХ-ноос сонгуулийн дүнг нэгтгэж олон нийтэд танилцуулах үе	1	2	3	4	9

4. Доор дурдсан байр суурьтай Таны бодол хэр зэрэг нийцдэг вэ?

	Нийцдэг	Бага зэрэг нийцдэг	Төдийлөн нийцдэггүй	Нийцдэггүй	Мэдэхгүй/ Хариулаагүй
4.1 Авлига манай улсад тогтсон заншил болсон.	1	2	3	4	9
4.2 Өнөөгийн улс төрийн тогтолцоо <sup>1</sup> авлигыг зогсоохын тулд амжилттай тэмцэж байна.	1	2	3	4	9
4.3 а. Иргэний нийгэм авлигыг урьдчилан сэргийлж чадна.	1	2	3	4	9
4.3 б. Зөвхөн төрийн байгууллагууд л авлигыг урьдчилан сэргийлэхэд тусалж чадна.	1	2	3	4	9
4.4 Өнөөгийн нөхцөлд иргэдийн хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд авлигын эсрэг тэмцэх гол хүчин юм.	1	2	3	4	9
4.5 Улс төрчид авлигаас тодорхой ашиг хонжоо олдог учраас бодит хэрэг дээрээ авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл байдаггүй.	1	2	3	4	9
4.6 Нийгэмд газар авсан хүнд суртлыг гэтлэн давах цорын ганц арга нь хээл хахууль өгөх явдал юм.	1	2	3	4	9
4.7 Авлигаас болж том бизнесийнхэнээс илүүтэйгээр жижиг, дунд бизнес эрхлэгчид хохирдог.	1	2	3	4	9
4.8 Авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрнө.	1	2	3	4	9
4.9 Том бизнес авлигын гол эх үүсвэрийн нэг нь.	1	2	3	4	9

4.10	Хээл хахууль нь зарим үед шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг.	1	2	3	4	9
4.11	Орон нутгийн захиргааны албан хаагчид ихэнхдээ итгэл үзүүлж болохуйц, хариуцлагатай хүмүүс байдаг.	1	2	3	4	9
4.12	Авлигыг багасгахад иргэд өөрсдөө хариуцлагатай байх ёстой.	1	2	3	4	9
4.13	Авлигын эсрэг өнөөгийн хууль үр дүнтэйгээр хэрэгжихгүй байна.	1	2	3	4	9
4.14	Шийдвэр гаргагчид өөрсдөө авлигаас төдийлөн хохирдоггүй, жирийн иргэд л авлигын дарамтыг илүү мэдэрч байгаа.	1	2	3	4	9
4.15	Төрийн албан хаагчид бага цалин авч байгаа нь хээл хахуулийн нэг гол шалтгаан болдог.	1	2	3	4	9
4.16	Албан тушаалтнуудад хатуу ял шийтгэл оногдуулах нь авлигыг зогсооно.	1	2	3	4	9
4.17	Авлига тодорхой түвшинд цаашид байсаар байх болно	1	2	3	4	9
4.18	Хээл хахууль өгсөн хүн түүнийг авсан хүнтэй адил гэм буруутай.	1	2	3	4	9
4.19	Авлигатай тэмцэх бодлогын хэрэгжүүлэлт улс төрийн сонирхол агуулаагүй.	1	2	3	4	9

5.	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	Ихээхэн өссөн	1.
		Бага зэрэг өссөн	2.
		Хэвээр үлдсэн	3.
		Бага зэрэг буурсан	4.
		Ихээхэн буурсан	5.
		Хэлж мэдэхгүй/Хариулаагүй	9.

6.	Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?	Ихээхэн өснө	1.
		Бага зэрэг өснө	2.
		Хэвээр үлдэнэ	3.
		Бага зэрэг буурна	4.
		Ихээхэн буурна	5.
		Хэлж мэдэхгүй/Хариулаагүй	9.

**В хэсэг. Авлигатай тэмцэх**

7.	Авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (1 сонголт хийнэ)	Засгийн газар	1.
		Орон нутгийн засаг захиргаа	2.
		Хууль сахиулах байгууллага	3.
		Иргэд (иргэдийн хөдөлгөөн)	4.
		Улсын Их Хурал	5.
		Шүүхийн байгууллагууд	6.
		Төрийн бус байгууллагууд	7.
		Ерөнхийлөгч	8.
		Авлигатай тэмцэх газар	9.
		Хууль зүйн яам	10.
		Хувийн хэвшил	11.
		Бусад (тодорхой бичих):	12.
8.	Таны бодлоор одоогийн Засгийн газар (Ерөнхий сайд Сайханбилэг тэргүүлж буй) өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ?	Авлигын асуудлыг илүү сайн шийдвэрлэж байна	1.
		Өмнөхтэйгээ адил байна	2.
		Өмнөхөөсөө дор байна	3.
		Хэлж мэдэхгүй /Хариулаагүй	9.

**9. Авлигатай тэмцэхэд доорх хүчин зүйлсүүд саад тотгор болдог уу?**

	Огт үгүй	Бага зэрэг	Тодорхой хэмжээгээр	Их хэмжээгээр	Мэдэхгүй/ Хариулаагүй
9.1 Төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ур чадвар муу	1	2	3	4	9
9.2 Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад улс орны тувшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй	1	2	3	4	9
9.3 Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад орон нутгийн тувшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй	1	2	3	4	9
9.4 Хүндрэлтэй асуудлыг хууль дүрмийн дагуу бус хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон	1	2	3	4	9
9.5 Хууль сахиулах байгууллагын хүрээнд авлига газар авсан	1	2	3	4	9
9.6 Олон нийтийн идэвхгүй байдал	1	2	3	4	9
9.7 Авлигатай тэмцэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл нь боловсронгуй биш	1	2	3	4	9

10.	Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ? (1 сонголт хийнэ)	Хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах	1.
		Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх	2.
		Засаг захиргааны шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, ил тод болгох	3.
		Төрийн зүгээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгох	4.
		Иргэд, төрийн бус байгууллагуудын зүгээс төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгох	5.
		Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх	6.
		Хуулиа тогтвортой хэрэгжүүлэх	7.
		Бусад (тодорхой бичих)	8.

11.	2006 онд Авлигын эсрэг шинэ хууль батлагдсан. Та шинэ хуулийн хүрээнд аль нэг албан тушаалтан шийтгүүлсэн тухай сонссон уу?	Тийм	1.
		Үгүй	2.

12.	Та авлигын талаар мэдээлэл авах утас ажиллаж байгааг мэдэх үү?	Тийм	1.
		Үгүй	2.

13.	Хэргээ Авлигатай Тэмцэх газар нэр хаягүй мэдээлэл хүлээж авна гэвэл Та авлигын талаар мэдээлэл өгөх үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		Мэдэхгүй / Хариулаагүй	9.

С хэсэг. Байгууллагууд

14.	Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг Та хэрхэн үнэлж байна вэ?	Их сайн	1.
		Харьцангуй сайн	2.
		Сайн ч биш, муу ч биш	3.
		Тааруухан	4.
		Муу	5.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.

15.	Авлигатай тэмцэх газарт Та хэр зэрэг итгэдэг вэ?	Их итгэдэг	1.
		Итгэдэг	2.
		Бараг итгэдэггүй	3.
		Огт итгэдэггүй	4.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.

16.	Та Авлигатай тэмцэх газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддаг итгэдэг үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.



17. Манай улсын нийгэм, эдийн засгийн доорх салбаруудад авлига хэр зэрэг тархсан гэж Та боддог вэ?

Авлигад автагдсан байдал Салбарууд	Огт үгүй	Бага зэрэг	Тодорхой хэмжээгээр	Нэлээд хэмжээгээр	Маш ихээр	Хэлж мэдэхгүй / Хариулаагүй
17.1 Гааль	1	2	3	4	5	9
17.2 Боловсролын тогтолцоо	1	2	3	4	5	9
17.3 Эрүүл мэндийн тогтолцоо	1	2	3	4	5	9
17.4 Шүүхийн тогтолцоо	1	2	3	4	5	9
17.5 Хууль сахиулах байгууллага	1	2	3	4	5	9
17.6 Улс төрийн намууд	1	2	3	4	5	9
17.7 Хууль тогтоох байгууллага /Улсын Их Хурал/	1	2	3	4	5	9
17.8 Засгийн газар	1	2	3	4	5	9
17.9 Орон нутгийн засаг захиргаа	1	2	3	4	5	9
17.10 Бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлдэг албад (төрснийг, гэр бүл болсныг иргэний журмаар бүртгэх, лиценз, зөвшөөрөл олгох)	1	2	3	4	5	9
17.11 Татварын алба	1	2	3	4	5	9
17.12 Уул уурхайн салбар	1	2	3	4	5	9
17.13 Газрын асуудал эрхэлсэн албад	1	2	3	4	5	9
17.14 Мэргэжлийн хяналтын газар	1	2	3	4	5	9
17.15 Орон нутгийн ханган нийлүүлэх тендерууд	1	2	3	4	5	9
17.16 Банк, санхүүгийн байгууллагууд	1	2	3	4	5	9

18.	Та өөр авлига өргөн тархсан байгууллага нэрлэж чадах уу?	
-----	--	--

Е хэсэг. Хувийн туршлага

19.	Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (гол нэгийг сонгоно уу)	Би хээл хахууль өгөхгүй	1.
		Аль нэг газарт мэдэгдэх болно (асуулт 20-ийг хариулна)	2.
		Мөнгө байвал хахууль өгнө	3.
		Хахууль өгөлгүйгээр асуудлыг шийдвэрлэхэд туслах хэн нэгнийг хайх болно	4.
		Би юу ч хийлгүй нөхцөл байдал өөрчлөгдөхийг хүлээх болно.	5.
		Мэдэхгүй/Хариулаагүй	9.

20.	Хэрвээ мэдэгдэх болвол хаана?  (гол нэгийг сонгоно уу)	Удирдлага <sup>2</sup> /Тухайн байгууллагын/	1.
		Авлигатай тэмцэх газар	2.
		Цагдаа	3.
		Хэвлэл мэдээлэл	4.
		ЗГ-ын 11-11 утас	5.
		Өөр	6.
21.	Авлигын талаарх голлох мэдээллээ Та аль эх сурвалжаас авдаг вэ?  (гол нэгийг сонгоно уу)	ТВ (асуулт 22-г хариулна)	1.
		Сонин, хэвлэл	2.
		Интернет, Social Media /форум, блог/ (асуулт 23-г хариулна)	3.
		Радио	4.
		Өөрт тохиолдсон туршлагаас	5.
		Найз нөхөд, хамаатан садан	6.
		Ам дамжсан яриа	7.
		Бусад эх сурвалж (тодорхой бичих):	8.
22.	Авлигын талаар хамгийн их мэдээлдэг сувгийг нэрлэнэ үү? (гол нэгийг нэрлэнэ үү)		
23.	Авлигын талаар хамгийн их мэдээлэл дамждаг хэрэгсэл /сайт/-ийг нэрлэнэ үү?  (гол нэгийг нэрлэнэ үү)	Фейсбук /Facebook/	1.
		Твиттер /Twitter/	2.
		Мэдээллийн сайтууд	3.
		Өөр(тодорхой бичих):	4.

ОДОО ДАРААГИЙН АСУУДАЛ РУУ ШИЛЖЬЕ.

24. Та доорх салбаруудад үйлчлүүлэх болвол тантай хэр зэрэг шударга харьцана гэж бодож байна вэ?

Салбарууд	Шударга бус	Бага зэрэг	Харьцангуй	Шударга	Мэдэхгүй
1. Боловсролын салбар	1	2	3	4	9
2. Эрүүл мэнд	1	2	3	4	9
3. Шүүхийн тогтолцоо	1	2	3	4	9
4. Хууль сахиулах байгууллага	1	2	3	4	9
5. Орон нутгийн захиргаа	1	2	3	4	9
6. Төрийн захиргаа	1	2	3	4	9

25.	Та сонирхолын зөрчлийн хууль батлагдсаныг мэдэх үү?	Тийм	1.
		Үгүй	2.

26.	Хэрвээ Та ашиг сонирхолын зөрчлийн талаар мэдвэл аль нэг газарт мэдэгдэх үү?	Тийм (асуулт 27-г хариулна)	1.
		Үгүй (асуулт 28-рүү шилжинэ)	2.

27.	Хэрвээ мэдэгдэх болвол хаана?  (гол нэгийг сонгоно уу)	Удирдлага <sup>3</sup> /тухайн байгууллагын/	1.
		Авлигатай тэмцэх газар	2.
		Цагдаа	3.
		Хэвлэл мэдээлэл	4.
		ЗГ-ын 11-11 утас	5.
		Өөр	6.

28.	Таны бодлоор Төрийн үйлчилгээний ажилтанууд сонирхолын зөрчилд хэр их ордог вэ?	Байнга	1.
		Хааяа	2.
		Бараг үгүй	3.
		Огт үгүй	4.
		Мэдэхгүй/хариулаагүй	9.

29.	Сүүлийн 3 сарын хугацаанд Таны болон танай гэр бүлийн гишүүдийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн үү?	Тийм	1.	
		Үгүй	F хэсэг рүү шилжинэ	2.
		Мэдэхгүй	F хэсэг рүү шилжинэ	3.
		Татгалзсан	F хэсэг рүү шилжинэ	4.

	30 .Сүүлийн 3 сарын хугацаанд Та хэнд хахууль өгсөн бэ? (олон сонголттой)	31. Хэрвээ өгсөн бол ойролцоогоор хэдийг өгсөн бэ?
1.	Багшид	
2.	Эрүүл мэндийн салбарын ажилтанд	
3.	Төрийн захиргааны байгууллагын ажилтанд	
4.	Цагдаагийн ажилтанд	
5.	Шүүгчид	
6.	Өмгөөлөгч/хуульчид	
7.	Прокурорт	
8.	Татварын байцаагчид	
9.	Нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтанд	
10.	Гаалийн байцаагчид	
11.	Орон нутгийн захиргааны ажилтанд	
12.	Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд /сонин, телевиз, радио/	
13.	Бусад (тодорхой бичих):	



32.	Таны хахуульд өгсөн мөнгөний нийт дүн Танай өрхийн төсөвт хэр зэрэг нөлөөлсөн бэ?	Огт нөлөөлөөгүй	1.
		Бага зэрэг	2.
		Тодорхой хэмжээгээр	3.
		Нилээд	4.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.
33.	Таны хахууль өгөх болсон гол шалтгаан юу байсан бэ?  (гол нэгийг сонгоно уу)	Хахуулийг шууд нэхсэн	1.
		Эрх мэдэлтнүүдтэй холбогдож хүндрэлд орохгүйн тулд хахууль өгсөн	2.
		Хүртэх ёстой үйлчилгээг авахын тулд хахууль өгсөн	3.
		Аль нь ч биш	4.

F хэсэг. Төр засгийн ил тод байдал. 34. Төр засгийн үйл ажиллагааны ил тод байдал болон үр дүнт байдлыг дээшлүүлэхэд дараах арга хэмжээнүүд хэр ЧУХАЛ гэж та бодож байна вэ?

	Огт үгүй	Бага зэрэг	Тодорхой хэмжээнд	Нилээд их	Маш их	Мэдэхгүй/Хариулаагүй
Шилэн дансны хууль	1	2	3	4	5	9
Бүртгэлийн цахим машин, нэг цонхны үйлчилгээ гэх мэт шинэ технологиуд	1	2	3	4	5	9
Төрийн албан хаагчдаас тогтмол гаргуулж авдаг орлогын мэдүүлэг	1	2	3	4	5	9
Улс төрийн намууд болон зарим УИХ гишүүдийн гаргаж буй сонгуулийн хуулийг сайжруулах тухай санаачлагууд	1	2	3	4	5	9
Элбэгдоржийн "Иргэний оролцоо-Шууд ардчилал"-ын санаачлага	1	2	3	4	5	9

35. Төр засгийн үйл ажиллагааны үр дүнт болон ил тод байдлыг сайжруулах зорилгоор авч байгаа арга хэмжээнүүдийг хэр зэрэг ҮР ДҮНТЭЙ байна гэж та бодож байна вэ?

	Огт үгүй	Бага зэрэг	Тодорхой хэмжээнд	Нилээд их	Маш их	Мэдэхгүй/Хариулаагүй
Шилэн дансны хууль	1	2	3	4	5	9
Бүртгэлийн цахим машин, нэг цонхны үйлчилгээ гэх мэт шинэ технологиуд	1	2	3	4	5	9
Төрийн албан хаагчдаас тогтмол гаргуулж авдаг орлогын мэдүүлэг	1	2	3	4	5	9
Улс төрийн намууд болон зарим УИХ гишүүдийн гаргаж буй сонгуулийн хуулийг сайжруулах тухай санаачлагууд	1	2	3	4	5	9
Элбэгдоржийн "Иргэний оролцоо-Шууд ардчилал"-ын санаачлага	1	2	3	4	5	9

G хэсэг. Дээд түвшний буюу Их авлига

38.	Та Их /дээд түвшний/ авлигыг юу гэж ойлгож байна вэ?	Бизнес, улс төрийн бүлэглүүдийн сонирхол бүхий	1.
		Төрийн өндөр албан тушаалтнууд оролцсон	2.
		Гадаадын болон дотоодын том бизнесийн оролцоотой авлига	3.
		Улс оронд их хэмжээний хохирол учруулсан	4.
		Зохион байгуулалттай бүлэглэл, сүлжээний оролцоотой	5.
		Авлигын хэмжээ маш их	6.
		Бусад (тодруулна уу):	7.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.

39.	Таны бодлоор Их /дээд түвшний/ авлига Монголд ямар түвшинд байна вэ?	Их хэмжээтэй	1.
		Зарим нэг тохиолдол бий	2.
		Цөөн хэдэн тохиолдол бий	3.
		Их авлига Монголд байхгүй	4.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.

40.	Таны бодлоор яагаад дээд түвшний авлига оршиж байна вэ?	Монгол улсын хууль эрх зүйн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, ийм түвшний асуудлыг авч шийдэж чадахгүй учраас	1.
		Монголын эдийн засагт бараг хяналтгүй их хэмжээний мөнгө байгаа учраас	2.
		Төр засгийн дээд түвшинд ил тод байдал хангалтгүй учраас	3.
		Монголд үйл ажиллагаа явуулдаг гадны том компаниуд асуудлаа авилгалаар шийддэг түгээмэл практик бий болсон учраас	4.
		Монголын том компаниуд асуудлаа авилгалаар шийддэг түгээмэл практик бий болсон учраас	5.
		Бизнес, улс төрийн сонирхол нийлсэн учраас	6.
		Бусад (тодруулна уу):	7.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.

41.	Танд дээд түвшний авлигын хэмжээний талаар төсөөлөл байна уу?	Тийм	1.
		Үгүй	2.
		Мэдэхгүй/Хариулаагүй	9.

44.	Та дээд түвшний авлигын талаар хэр их олж сонсдог вэ?	Байнга	1.
		Хааяа	2.
		Хэзээ ч үгүй (Q46-руу шилжинэ)	3.
		Мэдэхгүй/Хариулаагүй (Q46-руу шилжинэ)	9.

45.	Хэрэв сонссон бол ямар хэлбэрийн авлига байсан бэ? (Хэдийг ч сонгож болно)	Бэлэн мөнгө	1.
		Том хэмжээний бэлэг /байр, машин гэх мэт/	2.
		Бизнесийн түншлэл буюу хувьцаа	3.
		Гадаадад аялуулах	4.
		Албан тушаал	5.
		Өөр (тодруулна уу):	6.
		Мэдэхгүй/Хариулаагүй	7.
46.	Дээд түвшиний авлига Таны болон гэр бүлийн амьдралд хэр нөлөөлдөг вэ?	Маш их	1.
		Тодорхой хэмжээнд	2.
		Бага хэмжээнд	3.
		Огт үгүй (Q49-руу шилжинэ)	4.
		Мэдэхгүй/Хариулаагүй (Q49-руу шилжинэ)	9.
47.	Хэрвээ дээд түвшиний авлига Таны болон танай гэр бүлийн амьдралд сөргөөр нөлөөлдөг бол ямар байдлаар гэдгийг тодорхой хэлнэ үү? (1 сонголт хийнэ)	Амьжиргааны түвшин буурж байна	1.
		Гэр бүлийн бизнес муудаж байна	2.
		Хүнд суртал, ил тод байдал дутагдалтай байна	3.
		Төрийн үйлчилгээ хангалтгүй	4.
		Үнийн өсөлтөд нөлөөлж байна	5.
		Байгаль орчинд нөлөөлж байна	6.
		Өөр (тодруулна уу):	7.
Мэдэхгүй/Хариулаагүй	9.		
48.	Дээд түвшиний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (1 сонголт хийнэ)	Засгийн газар	1.
		Орон нутгийн засаг захиргаа	2.
		Хууль сахиулах байгууллага	3.
		Иргэд (иргэдийн хөдөлгөөн)	4.
		Улсын Их Хурал	5.
		Шүүхийн байгууллагууд	6.
		Төрийн бус байгууллагууд	7.
		Ерөнхийлөгч	8.
		Авлигатай тэмцэх газар	9.
		Хууль зүйн яам	10.
		Хувийн хэвшил	11.
		Бусад (тодорхой бичих):	12.

БҮХ ХҮНЭЭС АСУУНА

49	Дээд түвшний авлигатай тэмцэхэд дараах арга хэмжээнүүдийн аль нь хамгийн их үр дүнтэй гэж та бодож байна вэ? (хоёр хүртэл хариулт сонгож болно).	Хууль сахиулах байгууллагад илүү их эрх мэдэл олгох	1
		Орлогын мэдүүлгээ худлаа бөглөсөн тохиолдолд илүү хатуу хариуцлага тооцох	2
		Иргэний байгууллагуудын оролцоо, чадавхийг сайжруулах	3
		Авлигатай тэмцэх хууль эрх зүйг боловсронгуй болгох	4
		Авлигатай тэмцэх ёс суртахууныг нэмэгдүүлэхэд анхаарах	5
		Бие даасан хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дэмжих	6
		Авлигалын эсрэг чанга хөтөлбөртэй улс төрийн намуудыг дэмжих	7

Н хэсэг. Судалгаанд оролцогчдын нийгэм, эдийн засгийн байдлын талаарх мэдээлэл:

<p>1. Төрсөн он: 19.....</p> <p>2. Хүйс: Эр..... 1 Эм..... 2</p> <p>3. Боловсрол: үгүй..... 1 Бусадбага/бүрэн бус дунд..... 2 дунд..... 3 тусгай дунд..... 4 дээд..... 5</p>	<p>4. Ажил ( аль нэгийг нь сонгоно уу ) үндсэн ажил..... 1 гэрээт буюу цагийн ажил..... 2 мэргэжлийн дадлага..... 3 ажилгүй..... 4 гэрт байдаг..... 5 тэтгэвэр/тэтгэмж..... 6 цэрэг..... 7 оюутан/сурагч..... 8</p> <p>⇒ Ажлын 6-аас 8-ийг сонгосон бол Нийгмийн байдал мөн Харьяалал хариулах шаардлагагүй</p>	<p>5. Нийгмийн байдал: • ажилчин..... 1 • албан хаагч..... 2 • хувиараа хөдөлмөр..... 3 эрхлэгч ( бизнес ) • малчин/тариачин..... 4 • сэхээтэн..... 5</p> <p>6. Харъяалал: сонгуульт буюу тангараг өргөсөн төрийн а/х..... 1 төсвийн бусад байгууллага..... 2 хувийн / холимог сектор..... 3 төрийн бус байгууллага..... 4</p>		
<p>7. Гэрлэлтийн байдал: Гэрлэсэн - Баталгаатай ..... 1 Гэрлэсэн - Баталгаагүй..... 2 Гэрлээгүй ..... 3 Тусдаа амьдардаг/салсан..... 4 Бэлэвсэн..... 5</p>	<p>8. Өрхийн ам бүлийн тоо:</p> <p>9. Өрхийн хэдэн гишүүн ажил эрхэлдэг вэ?:</p>	<p>10. Өрхийн орлого (татвар, НДШ төлөхөөс өмнө):</p> <table border="1"> <tr> <td>Сарын байдлаар:</td> <td>Жилийн байдлаар:</td> </tr> </table>	Сарын байдлаар:	Жилийн байдлаар:
Сарын байдлаар:	Жилийн байдлаар:			
<p>11. Хаяг: Хот/Аймаг</p> <p>12. Утас<sup>4</sup>:</p> <p>13. Ярилцлага авсан ажилтан</p>	<p>Дүүрэг/Сум</p> <p>Хороолбаг</p>			

<sup>1</sup> Ерөнхийлөгч-Парламент-Засгийн газрын холимог гурвалсан тогтолцоо

<sup>2</sup> Тухайн авлигын тохиолдол гарсан байгууллагын удирдлагыг ойлгоно. Жишээ нь: тухайн газар нь их дэлгүүр бол тухайн дэлгүүрийн удирдлагад хандана гэсэн ойлголт.

<sup>3</sup> Тухайн авлигын тохиолдол гарсан байгууллагын удирдлагыг ойлгоно. Жишээ нь: тухайн газар нь их дэлгүүр бол тухайн дэлгүүрийн удирдлагад хандана гэсэн ойлголт.

<sup>4</sup> Судалгаанд оролцогч утасны дугаараа өгөхийг зөвшөөрсөн тохиолдолд. Судалгаанд хяналт тавих зорилгоор ашиглагдана.



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

